



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/95

Мандалговь

Мэргэжилтний баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 36 дугаар зүйл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 83 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3-ийн “Амар тайван, аюулгүй нийгэм” бүлгийн 4.3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдан архинд донтох өвчнийг эдгэрүүлэх болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тодорхой үр дүнд хүрч буй Архичид аминчлахуй(АА) болон Давхар хамаарлын бүлэг(Ал-Анон), Давхар хамааралтай хүүхдүүдийн бүлэг(Алатен), Архичдын болон асуудалтай гэр бүлд өссөн насанд хүрсэн хүмүүсийн бүлэг(АСА) нөхөрлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор аймгийн хэмжээнд ажиллах чиг үүрэг бүхий “Мэргэжилтний баг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, суманд ажиллах “Мэргэжилтний баг”-ийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Архичид аминчлахуй болон давхар хамаарлын бүлгүүдийн үйл ажиллагаа явуулж буй орон байрны багтаамж, нөхцөл байдлыг сайжруулах, цаашид шинээр үүсэн бий болж байгаа бүлгүүд уулзалт, ярилцлага явуулах орон байртай болох санал хүсэлтийг бодлогын хүрээнд дэмжиж, мөн сумдад ажиллах “Мэргэжилтний баг”-ийг байгуулж ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд ажиллах мэргэжилтний багийн үйл ажиллагааны зардлыг тухай бүр Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван)-т зөвшөөрсүгэй.

4822100239

4. Аймаг болон сумдад үйл ажиллагаа явуулж буй “Мэргэжилтний баг”-ууд дээрх нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах явцдаа тэдний мөрддөг уламжлал, зарчмыг хүндэтгэн ажилласугай.

5. Мэргэжилтний багийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг тухай бүр мэдээлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс(Л.Баярсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ


Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 11-ний өдрийн 45 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЙМГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Багийн ахлагч: -Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт сурталчилгаа, авлигаас урьдчилан сэргийлэх бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн
- Гишүүд:
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, хүн ам зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн
 - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан
 - Аймгийн Эрүүл мэндийн газрын НЭМТ-ийн халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
 - Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэдрэл, сэтгэцийн их эмч
 - Аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн
 - Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын тасгийн ахлах байцаагч
 - Аймгийн Цагдаагийн газрын Сэтгэл зүйч

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар
сарын 11-ний өдрийн 145 дугаар
захирамжийн хоёрдүгээр хавсралт



СУМЫН МЭРГЭЖИЛТНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Багийн. ахлагч: -Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
- Нарийн бичгийн дарга: -Сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
- Гишүүд:
- Сумын Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн мэргэжилтэн
 - Сумын Эрүүл мэндийн төвийн НЭМ-ийн мэргэжилтэн
 - Багийн Засаг дарга нар
 - Багийн Нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч
 - Сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч